



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/10/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Ж.Энхтуяа
Утас: 261628 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хүлэгтхүннү Аудит ХХК
Гүйцэтгэх захирал: И.Гүррагчаа
Цахим хаяг: guragchaa@hulegthunnu.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Аудит хийсэн зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, тодруулга	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Албан шаардлага	20
4.3 Зөвлөмж	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны яам
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О.АЛТАНГОО
ТАНАА

2022.03.15 № 07/606
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол улсын боловсролын их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монгол улсын боловсролын их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн/захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,474,360,041.27	32,371,201,031.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,982,716,728.08	21,491,697,355.48
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	13,292,135,948.92	15,393,779,169.97
31210	Төгрөг	13,292,135,948.92	15,393,779,169.97
31213	Арилжааны банк дахь харилцах	13,292,135,948.92	15,393,779,169.97
31500	Хадгаламж	6,690,580,779.16	6,097,918,185.51
33	АВЛАГА	11,169,871,464.49	10,550,554,653.02
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	8,141,582.00	14,337,689.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	8,804,990,522.59	8,250,946,760.26
33500	Бусад авлага	2,356,739,359.90	2,285,270,203.76
33510	Байгууллагаас авах авлага	2,352,667,508.90	2,262,588,439.25
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,071,851.00	22,681,764.51
34	УРЬДЧИЛГАА	219,972,419.00	189,291,165.00
34600	Урьдчилж гарсан зардал	177,496,560.00	163,542,165.00
34710	Урьдчилгаа тооцоо	42,475,859.00	25,749,000.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	17,510,500.00	11,550,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	10,348,000.00	14,199,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	14,617,359.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	101,799,429.70	139,657,857.95
35100	Түүхий эд материал	847,625.00	1,163,373.50
35130	Эм боох материал	847,625.00	1,163,373.50
35400	Хангамжийн материал	100,951,804.70	138,494,484.45
35410	Бичиг хэргийн материал	52,537,218.50	30,535,675.00
35420	Аж ахуйн материал	47,316,336.20	105,353,946.25
35430	Сэлбэг хэрэгсэл	156,400.00	151,800.00
35460	Хүнсний материал	-	1,511,213.20
35470	Бусад хангамжийн материал	941,850.00	941,850.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	69,832,749,138.96	68,084,995,214.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	69,832,749,138.96	68,084,995,214.43
39200	Биет хөрөнгө	66,720,463,263.32	65,434,598,477.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	58,915,895,226.10	58,915,895,226.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,548,285,183.22)	(5,292,436,312.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	420,831,044.67	342,939,756.21
39204	Хуримтлагдсан элэгдэл	(188,025,005.12)	(182,945,197.77)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	9,923,124,946.51	10,758,795,850.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,075,768,751.79)	(6,210,830,878.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,286,109,173.14	6,476,662,260.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,852,656,740.46)	(4,214,456,978.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,363,244,946.07	1,362,502,673.11
39215	Хуримтлагдсан элэгдэл	(275,217,215.34)	(395,138,031.58)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,543,277,420.00	2,556,991,954.20
39217	Ном	1,207,933,402.76	1,316,618,156.76
39300	Биет бус хөрөнгө	3,112,285,875.64	2,650,396,736.95
39301	Програм хангамж	2,131,203,677.40	2,183,428,752.53
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,047,401,687.22)	(1,407,925,255.58)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,028,483,885.46	1,874,893,240.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>101,307,109,180.23</u>	<u>100,456,196,245.88</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7,843,592,314.52</u>	<u>9,130,068,247.88</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>7,843,592,314.52</u>	<u>9,130,068,247.88</u>
41300	Өглөг	<u>171,350,137.33</u>	<u>506,850,452.91</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,434,206.34	35,399,458.65
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,314,348.93
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	43,218,200.00	43,218,200.00
41360	Бусад өглөг	<u>115,697,730.99</u>	<u>424,918,445.33</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	113,858,517.00	420,078,900.05
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,515,873.99	838,219.28
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	323,340.00	4,001,326.00
41400	Урьдчилж орсон орлого	<u>7,672,242,177.19</u>	<u>8,623,217,794.97</u>
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,006,775,736.94	774,784,996.88
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	6,665,466,440.25	7,848,432,798.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>93,463,516,865.71</u>	<u>91,326,127,998.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>93,463,516,865.71</u>	<u>91,326,127,998.00</u>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,462,707,319.69	14,309,116,674.23
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	14,462,707,319.69	14,309,116,674.23
51200	Хуримтлагдсан үр дүн	<u>46,443,472,016.22</u>	<u>44,459,851,608.60</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	46,652,673,150.70	46,872,572,710.18
51220	Тайлант үеийн үр дүн	(209,201,134.48)	(2,412,721,101.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	<u>32,557,337,529.80</u>	<u>32,557,159,715.17</u>
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>101,307,109,180.23</u>	<u>100,456,196,245.88</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	34,253,149,163.97	32,364,648,410.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,980,240,863.97	32,010,228,110.23
120	Нийтлэг татварын бус орлого	33,937,740,863.97	32,010,228,110.23
120002	Хүүгийн орлого	1,472,029,646.24	594,021,036.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,162,438,723.93	31,078,214,104.04
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,344,190,850.56	29,548,038,311.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,141,320.18	334,478,907.52
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	468,230,027.80	634,603,011.34
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,234,876,525.39	561,093,873.83
120005	Түрээсийн орлого	29,767,606.00	38,634,972.00
120009	Бусад орлого	1,273,504,887.80	299,357,997.35
122	Тусламжийн орлого	42,500,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	42,500,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	272,908,300.00	354,420,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	272,908,300.00	354,420,300.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	7,950,000.00	33,500,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	264,958,300.00	320,920,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	34,495,663,786.20	34,780,205,381.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,495,663,786.20	34,780,205,381.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,436,085,608.20	34,354,754,625.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,199,768,223.44	20,450,803,118.33
210101	Үндсэн цалин	19,199,768,223.44	20,450,803,118.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,399,574,191.89	2,647,978,068.06
210201	Тэтгэврийн даатгал	1,648,743,118.44	1,854,704,036.48
210202	Тэтгэмжийн даатгал	157,640,356.48	190,513,094.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	174,934,718.52	173,828,302.91
210204	Ажилгүйдлийн даатгал	52,415,267.02	40,152,683.02
210205	Эрүүл мэндийн даатгал	365,840,731.43	388,779,951.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,383,869,758.33	1,203,375,145.79
210301	Гэрэл, цахилгаан	390,990,805.31	329,250,430.70
210302	Түлш, халаалт	856,594,886.09	731,168,181.09
210303	Цэвэр, бохир ус	136,284,066.93	142,956,534.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,528,948,949.88	1,636,945,885.15
210401	Бичиг хэрэг	242,339,856.35	229,038,572.77
210402	Тээвэр, шатахуун	27,180,638.49	31,745,991.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	238,947,447.07	231,872,551.53
210404	Ном, хэвлэл	54,989,468.00	117,061,339.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	54,557,754.00	95,300,357.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	465,368,779.97	395,664,261.96
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	445,528,006.00	536,262,811.89
210408	Бараа материал акталсны зардал	37,000.00	-
2105	Нормативт зардал	196,346,435.56	83,939,210.54
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,012,140.00	12,982,720.74

210502	Хоол, хүнс	177,742,795.56	57,216,689.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,591,500.00	13,739,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,010,735,736.00	1,132,806,214.17
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,014,483.00	11,593,600.00
210602	Тавилга	439,000.00	1,091,000.00
210604	Урсгал засвар	1,002,282,253.00	1,120,121,614.17
2107	Томилолт, зочны зардал	103,052,155.00	58,013,337.00
210701	Гадаад албан томилолт	37,499,611.00	9,017,160.00
210702	Дотоод албан томилолт	41,702,416.00	40,612,850.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	23,850,128.00	8,383,327.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	529,099,206.98	1,118,365,760.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	529,099,206.98	1,118,365,760.88
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,084,690,951.12	6,022,527,885.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,861,884.00	128,113,184.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,821,971,233.62	1,371,468,550.63
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,181,857,833.50	4,522,946,150.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,059,578,178.00	425,450,756.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,059,578,178.00	425,450,756.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	342,197,749.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,717,380,429.00	425,450,756.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	<u>(242,514,622.23)</u>	<u>(2,415,556,971.47)</u>
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	37,052,464.95	2,835,869.89
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	37,052,464.95	2,835,869.89
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,738,977.20	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,738,977.20	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	<u>(209,201,134.48)</u>	<u>(2,412,721,101.58)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>14,462,707,319.69</u>	<u>32,581,418,095.80</u>	<u>46,432,570,747.72</u>	<u>93,476,696,163.21</u>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	220,102,402.98	220,102,402.98
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,462,707,319.69	32,581,418,095.80	46,652,673,150.70	93,696,798,566.19
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(24,080,566.00)	-	(24,080,566.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	(209,201,134.48)	(209,201,134.48)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>14,462,707,319.69</u>	<u>32,557,337,529.80</u>	<u>46,443,472,016.22</u>	<u>93,463,516,865.71</u>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	429,100,693.96	429,100,693.96
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,462,707,319.69	32,557,337,529.80	46,872,572,710.18	93,892,617,559.67
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(177,814.63)	-	(177,814.63)
Өмчид гарсан өөрчлөлт	(153,590,645.46)	-	-	(153,590,645.46)
Тайлант үеийн үр дүн	-	-	(2,412,721,101.58)	(2,412,721,101.58)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	<u>14,309,116,674.23</u>	<u>32,557,159,715.17</u>	<u>44,459,851,608.60</u>	<u>91,326,127,998.00</u>

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	28,389,360,609.48	34,040,483,368.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,981,596,409.48	30,396,957,507.42
120	Нийтлэг татварын бус орлого	25,668,251,348.48	30,076,037,207.42
120002	Хүүгийн орлого	1,472,029,646.24	689,818,597.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,141,687,806.24	29,346,766,437.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,366,962,706.79	28,389,771,712.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,359,817.15	401,276,070.82
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	659,365,282.30	555,718,654.72
120005	Түрээсийн орлого	54,533,896.00	39,452,172.00
122	Тусламжийн орлого	48,386,761.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	48,386,761.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	264,958,300.00	320,920,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	264,958,300.00	320,920,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,407,764,200.00	3,643,525,861.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,407,764,200.00	3,643,525,861.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	2,407,764,200.00	3,643,525,861.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,693,809,742.55	30,179,879,944.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,693,809,742.55	30,179,879,944.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,175,926,294.55	29,625,727,159.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,248,570,118.94	20,417,037,683.35
210101	Үндсэн цалин	19,248,570,118.94	20,417,037,683.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,089,704,697.04	2,356,127,521.10
210201	Тэтгэврийн даатгал	648,296,417.78	1,762,124,522.09
210202	Тэтгэмжийн даатгал	45,593,816.67	116,427,740.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,175,229.53	89,085,484.66
210204	Ажилгүйдлийн даатгал	8,504,164.37	23,008,134.43
210205	Эрүүл мэндийн даатгал	351,135,068.69	365,481,639.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,379,200,480.33	1,208,916,283.83
210301	Гэрэл, цахилгаан	394,009,776.31	329,148,562.70
210302	Түлш, халаалт	848,082,320.09	736,569,187.13
210303	Цэвэр, бохир ус	137,108,383.93	143,198,534.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,115,419,376.49	1,327,852,036.25
210401	Бичиг хэрэг	110,542,235.00	118,376,820.00
210402	Тээвэр, шатахуун	27,770,776.00	34,707,577.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	239,737,587.07	231,872,551.53
210404	Ном, хэвлэл	86,408,428.00	209,589,693.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63,314,212.00	104,566,357.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	587,646,138.42	628,739,037.72
2105	Нормативт зардал	86,933,039.00	94,131,937.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,246,865.00	18,852,124.00
210502	Хоол, хүнс	63,604,374.00	61,087,513.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,081,800.00	14,192,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,550,788,630.50	1,202,998,110.55
210601	Багаж, техник, хэрэгсэл	320,707,330.00	47,442,350.00
210602	Тавилга	2,818,700.00	1,696,000.00
210604	Урсгал засвар	1,227,262,600.50	1,153,859,760.55
2107	Томилолт, зочны зардал	100,456,755.00	55,814,337.00
210701	Гадаад албан томилолт	48,710,407.00	9,017,160.00
210702	Дотоод албан томилолт	34,386,816.00	37,753,850.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	17,359,532.00	9,043,327.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	660,162,177.13	1,262,130,996.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	627,223,221.15	1,217,248,135.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	28,000,000.00	39,200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	799,964.00	645,696.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	645,000.00	481,650.00
210807	Газрын төлбөр	2,257,258.00	3,216,042.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,236,733.98	1,339,472.35
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,944,691,020.12	1,700,718,254.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	184,075,245.00	167,667,715.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,760,615,775.12	1,533,050,539.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	517,883,448.00	554,152,784.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	517,883,448.00	554,152,784.50
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	181,804,040.00	132,593,028.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	336,079,408.00	421,559,756.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	<u>695,550,866.93</u>	<u>3,860,603,424.09</u>
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,551,731,553.00	2,354,472,885.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,551,731,553.00	2,354,472,885.20
2200	Дотоод эх үүсвэрээр	3,551,731,553.00	2,354,472,885.20
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,551,731,553.00	2,354,472,885.20
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,551,731,553.00)	(2,354,472,885.20)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	37,052,464.95	2,850,088.51
14	Бусад эх үүсвэр	37,052,464.95	2,850,088.51
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	37,052,464.95	2,850,088.51
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	<u>(2,819,128,221.12)</u>	<u>1,508,980,627.40</u>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,801,844,949.20	19,982,716,728.08
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,982,716,728.08	21,491,697,355.48

2.5 Аудит хийсэн зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

			/төгрөгөөр/
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,597,608,273.00	31,541,587,112.43	16,056,021,160.57
УРСГАЛ ЗАРДАЛ	47,597,608,273.00	31,541,587,112.43	16,056,021,160.57
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,822,187,515.00	28,928,042,110.93	3,894,145,404.07
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,514,977,320.63	20,416,679,009.35	1,123,298,311.28
Үндсэн цалин	21,304,517,461.85	20,265,312,244.35	1,064,205,217.50
Нэмэгдэл	62,301,271.15	19,298,638.00	43,002,633.15
Унаа хоолны хөнгөлөлт	88,920,000.00	81,404,440.00	7,515,560.00
Урамшуулал	6,738,587.63	2,052,987.00	4,685,600.63
Гэрээт ажлын хөлс	52,500,000.00	48,610,700.00	3,889,300.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,757,506,081.37	2,356,127,521.10	404,378,560.27
Тэтгэврийн даатгал	2,152,506,081.37	1,762,124,522.09	393,381,559.28
Тэтгэмжийн даатгал	120,000,000.00	116,427,740.66	3,572,259.34
ҮОМШӨ-ний даатгал	90,000,000.00	89,085,484.66	914,515.34
Ажилгүйдлийн даатгал	25,000,000.00	23,008,134.43	1,991,865.57
Эрүүл мэндийн даатгал	370,000,000.00	365,481,639.26	4,518,360.74
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,722,208,074.00	1,208,916,283.83	513,291,790.17
Гэрэл, цахилгаан	504,873,987.00	329,148,562.70	175,725,424.30
Түлш, халаалт	992,451,823.00	736,569,187.13	255,882,635.87
Цэвэр, бохир ус	224,882,264.00	143,198,534.00	81,683,730.00
Хангамж, бараа материалын зардал	1,854,422,410.00	1,449,181,790.25	405,240,619.75
Бичиг хэрэг	124,085,350.00	118,376,820.00	5,708,530.00
Тээвэр, шатахуун	50,185,000.00	34,707,577.00	15,477,423.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	272,624,000.00	231,872,551.53	40,751,448.47
Ном, хэвлэл	585,337,960.00	317,916,947.00	267,421,013.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	132,220,000.00	104,566,357.00	27,653,643.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	689,970,100.00	641,741,537.72	48,228,562.28
Нормативт зардал	188,511,000.00	94,131,937.00	94,379,063.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,750,000.00	18,852,124.00	897,876.00
Хоол, хүнс	139,716,000.00	60,757,513.00	78,958,487.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,045,000.00	14,522,300.00	14,522,700.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,513,026,458.00	1,164,097,614.75	348,928,843.25
Багаж, техник, хэрэгсэл	422,549,380.00	381,971,775.00	40,577,605.00
Тавилга	233,005,000.00	220,958,590.00	12,046,410.00
Урсгал засвар	857,472,078.00	561,167,249.75	296,304,828.25
Томилолт, зочны зардал	233,966,200.00	55,814,337.00	178,151,863.00
Гадаад албан томилолт	74,000,000.00	9,017,160.00	64,982,840.00
Дотоод албан томилолт	95,376,200.00	37,753,850.00	57,622,350.00

Зочин төлөөлөгч хүлээн авах	64,590,000.00	9,043,327.00	55,546,673.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,773,861,266.00	1,281,019,696.20	492,841,569.80
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,709,960,000.00	1,236,136,835.85	473,823,164.15
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	53,000,000.00	39,200,000.00	13,800,000.00
Даатгалын үйлчилгээ	1,575,000.00	-	1,575,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	2,266,266.00	645,696.00	1,620,570.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,060,000.00	481,650.00	578,350.00
Газрын төлбөр	3,900,000.00	3,216,042.00	683,958.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,100,000.00	1,339,472.35	760,527.65
Бараа үйлчилгээний бусад зардал	1,263,708,705.00	902,073,921.45	333,634,783.55
Бараа үйлчилгээний бусад зардал	186,800,000.00	178,928,535.00	9,871,465.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,076,908,705.00	723,145,386.45	323,763,318.55
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,102,364,275.00	421,559,756.50	11,680,804,518.50
Засгийн газрын урсгал шилжүүлэг	11,447,752,471.00	-	11,447,752,471.00
Оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлт урамшуулал	1,508,450,798.00	-	1,508,450,798.00
Эрсдлийн зардал	9,939,301,673.00	-	9,939,301,673.00
Бусад урсгал шилжүүлэг	654,611,804.00	421,559,756.50	233,052,047.50
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	654,611,804.00	421,559,756.50	233,052,047.50
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,673,056,483.00	2,191,985,245.00	481,071,238.00
Дотоод эх үүсвэрээр	2,673,056,483.00	2,191,985,245.00	481,071,238.00
Барилга байгууламж	956,006,483.00	896,512,510.00	59,493,973.00
Их засвар	740,000,000.00	705,744,535.00	34,255,465.00
Тоног төхөөрөмж	617,050,000.00	589,728,200.00	27,321,800.00
Бусад хөрөнгө	360,000,000.00	-	360,000,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,597,607,273.00	48,981,939,588.70	(1,384,332,315.70)
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	31,558,892,300.00	32,943,224,615.70	(1,384,332,315.70)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,550,421,100.00	32,155,636,802.02	(1,605,215,702.02)
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,008,471,200.00	787,587,813.68	220,883,386.32
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	16,038,714,973.00	16,038,714,973.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,982,716,728.08	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	21,491,697,355.48	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол улсын боловсролын их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад санхүү, татварын тайланг уялдаа холбоотой бэлтгэх, татварын үлдэгдлийг санхүүгийн үлдэгдэлтэй тааруулах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Хүлэгтхүннү Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Ичинхорол, аудитын менежер Ц.Дуламсүрэн, Э.Цолмон, аудиторын туслах Ц.Мишээл, Ү.Тэмүүжин нар гүйцэтгэж, чанарын хяналтыг гүйцэтгэх захирал И.Гүррагчаа, чанарын хяналтын менежер Е.Оюундэлгэр нар хэрэгжүүлсэн.

Монгол улсын боловсролын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн 1/141 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол улсын боловсролын их сургуулийн эрхэм зорилго нь хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай багш, боловсролын салбарын мэргэжилтэн бэлтгэн гаргах, эрдэм шинжилгээ, инноваци, сургалтын аргазүй, технологийг хөгжүүлэх, боловсролын үйлчилгээний чанарыг орчин үеийн их сургуулийн түвшинд хүргэх, багш боловсролын чанараар Ази тивд өрсөлдөхүйц их сургууль байх, сургалт, судалгаа хосолсон нээлттэй, орчин үеийн их сургууль байхад оршино.

Монгол улсын боловсролын их сургууль нь дээд боловсрол эзэмших, мэргэжил, боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх, хөгжих эрмэлзэл бүхий хувь хүний хөгжлийг дэмжих, шинжлэх ухаан, боловсролын судалгаа эрхлэх, багш, суралцагчдын бүтээлч үйл ажиллагааг дэмжих, үр дүнг хэрэгжүүлэх, боловсролын салбарын удирдах ажилтан, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, үйл ажиллагааны чанар, олон улсын түвшинд өрсөлдөх чадвар тасралтгүй тогтвортой дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд,
- Боловсролын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд,
- 2021 оны Засгийн газрын 43-р тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн эсэх, тус

байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон эсэх талаар тайлангийн 3.8 аудитын гол асуудлын хэсэгт дэлгэрэнгүй дурдав.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй боловч тайлант жилийн дундуур уг албанаас сургуулийн удирдлага, хүний нөөц, сургалт, санхүү, 2019-2020 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг гүйцэтгэж 15 зөрчилд зөвлөмж өгч, 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол улсын боловсролын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн “нийт зардал”-ыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн “нийт зардал”-ын 34,495.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 345.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Монгол улсын боловсролын их сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 850.9 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19,982.7	21,491.7	1,509.0
Авлага	11,169.9	10,550.5	(619.4)
Урьдчилгаа	220.0	189.3	(30.7)
Бараа материал	101.8	139.7	37.9
Үндсэн хөрөнгө	69,832.7	68,085.0	(1,747.7)
Нийт хөрөнгө	101,307.1	100,456.2	(850.9)
Өр төлбөр	7,843.6	9,130.1	1,286.5
Засгийн газрын хувь оролцоо	14,462.7	14,309.1	(153.6)
Хуримтлагдсан үр дүн	46,443.5	44,459.9	(1,983.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,557.3	32,557.1	(0.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	101,307.1	100,456.2	(850.9)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Тайлант жилд гадаад оюутнуудын сургалтын төлбөрийн орлого төлөвлөснөөс 50 хувиар өсөж мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,509.0 сая төгрөгөөр өссөн;
- Цар тахалтай холбоотойгоор өмнөх 2 жилд хуримтлагдсан сургалтын төлбөрийн авлага, БЗС-ийн буцалтгүй тусламж, оюутны хөгжлийн 900.0 сая төгрөгийн өмнөх оны зээл тайлант жилд тус тус төлөгдөж авлагын үлдэгдэл 619.4 сая төгрөгөөр буурсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь тайлант жилийн 4,522.9 сая төгрөгийн худалдан авалт, ТӨБЗГ-ын 737 дугаар тогтоолын дагуу хөрөнгийн анхны үнэ 494.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, газар эзэмших эрхийн дахин үнэлгээний 153.0 сая төгрөгийн үнэ цэнийн бууралт, 3,716.4 сая төгрөгийн элэгдлийн зардлаар тус тус буурсан;
- Тайлант жилд оюутнууд II улирлын сургалтын төлбөрөө урьдчилж төлснөөс 1,183.0 сая төгрөгөөр урьдчилж орсон орлого, Мөнгөн гануу ХХК-ны тендерийн барьцааны төлбөр болох 238.0 сая төгрөгөөр өр төлбөр тус тус нэмэгдсэн;

3.6 Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу сургуулийн захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.6.1 Зорилтот түвшний төлөвлөлт

Удирдах зөвлөлийн 2020 оны 8 дугаар тогтоолоор 2021 оны төсвийг 47,597.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 47,597.6 сая төгрөгийн зардал гарган ажиллахаар батлуулсан.

Удирдах зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор 2021 оны батлагдсан төсвийн эрсдэлийн зардлаас 233.9 сая төгрөгийг хасаж, эд хогшил, урсгал засварын зардлыг 204.4 сая төгрөгөөр, хангамж бараа материалыг зардлыг 19.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн зардлын бүлэг хооронд гүйлгэн зохицуулалт хийж батлуулсан байна.

3.6.2 Зорилтот түвшний гүйцэтгэл

Монгол улсын боловсролын их сургууль нь тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас нийт 47,597.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 48,981.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 102.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт-2 Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

					/сая төгрөг/
Д/Д	Орлого, зардлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	Нийт орлого	47,597.6	48,981.9	1,384.3	102.9
1.1	Үндсэн үйл ажиллагааны орлого	30,550.4	32,155.6	1,605.2	105.3
1.2	Туслах үйл ажиллагааны орлого	1,008.5	787.6	(220.9)	78.1
1.3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	16,038.7	16,038.7	-	100.0
2	Нийт зардал	47,597.6	31,541.6	(16,056.0)	66.3
2.1	Үйл ажиллагааны урсгал зардал	32,822.2	28,928.0	(3,894.2)	88.1
2.2	Урсгал шилжүүлэг	12,102.4	421.6	(11,680.8)	3.5
2.3	Хөрөнгийн зардал	2,673.0	2,192.0	(481.0)	82.0

Нийт орлогыг 32,155.6 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, 787.6 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого болон 16,038.7 сая төгрөгийн урьд оны үлдэгдлийн санхүүжилт тус тус бүрдүүлжээ.

Тайлант онд сургуулийн үйл ажиллагаанд зориулан 31,541.6 сая төгрөгийн зардал гарснаас 28,928.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаанд, 421.6 сая төгрөгийг урсгал шилжүүлэгт, 2,192.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулжээ.

Монгол улсын боловсролын их сургууль нь 2021 онд нийт зардалд 47,597.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 31,541.6 сая төгрөг зарцуулж 33.4 хувь буюу 16,038.7 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 1,123.3 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 404.4 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 513.3 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 405.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 473.8 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 348.9 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Тайлант онд гадаад төсөл, хөтөлбөрөөс нийт 634.6 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авснаас 44.9 сая төгрөгийг үндсэн хөрөнгө худалдан авахад, 589.7 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний хэрэгжилт 75.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 66.3 хувийн биелэлттэй, 8.7 хувь буюу 16,056.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт болон түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 8.7 хувь буюу 16,056.0 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь төсвийг хэмнэлттэй зарцуулж сургууль хүрэх үр дүндээ хүрч ажилласан байна.

Архангай аймгийн багшийн сургуулийн ашиглахгүй болж нураасан спорт заалны газар дээр барьсан багш, ажилчдын 40 айлын орон сууцны 1,261 м.кв талбайг нийтийн эзэмшилд, хичээлийн байрны 932.6 м.кв талбайг аймгийн 10 дугаар цэцэрлэгийн зориулалтаар тус тус ашиглуулж байна.

Түүнчлэн Архангай аймгийн багшийн сургуулийн эзэмшилд буй газрын талбайн хэмжээ 2018 оны дахин үнэлгээгээр өөрчлөгдсөн бөгөөд өөрчлөлтийг тусгуулахаар Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон ТӨБЗГ-т, 2019 онд Барилга хот байгуулалтын яаманд хандан хүсэлт өгсөн боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Монгол улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд тайлант онд удирдах зөвлөлийн нийт гишүүдэд 45.0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, орон сууцны хөнгөлөлт олгосон, мөн сургуулийн эзэмшилд 160.0 сая төгрөгийн дансны үнэтэй 9 авто машин бүртгэлтэй бөгөөд жолоочийн цалингийн зардалд 61.8 сая төгрөг, шатахууны зардалд 11.8 сая төгрөг, сэлбэг, тос, бусад зардалд 7.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний төлбөрийн мэдээллийг үзэхэд тайлант хугацаанд 13 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж 66.7 сая төгрөгийн зардал гаргасан ба энэ нь худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлж буй сургуулийн статус болон авлагын толилуулгатай холбоотой дээд шатны удирдлагын түвшинд шийдвэрлэх дараах гол асуудлууд байна. Үүнд:

1. Монгол улсын боловсролын их сургуулийн НБББББ-т нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх, нэгтгэхэд УСНББОУС-ыг баримтална гэж заасны дагуу уг стандартыг дагаж мөрддөг. Сургуулийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хариуцлагын хэлбэрийг төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж заасан бөгөөд шилэн дансны цахим хуудсанд ТӨҮГ гэсэн стауст харьяалагддаг. Мөн сургуулийн удирдлагын үйл ажиллагаа, үүргийг Дээд боловсролын тухай хуулийн 11.7-д "Ашгийн төлөө дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлагыг Компанийн тухай хуулиар зохицуулна." гэж заан Компанийн тухай хуулиар зохицуулдаг бөгөөд сургууль үйл ажиллагаагаа өөрөө санхүүжүүлдэг. Иймд уг асуудлыг хууль тогтоомжийн түвшинд тодорхой болгох, шийдвэрлүүлэх шаардлагатай байна.
2. БШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд мөрдөх бодлогын баримт бичиг, УСНББОУС-д нийцүүлэн сургууль нь өөрийн НБББББ-ийг батлуулан мөрдөж ажиллаж байна. Уг бодлогын баримт бичигт авлагын үлдэгдэлд найдваргүй авлагын нөөц байгуулна гэж заасан боловч сургууль хугацаа хэтэрсэн болон 1,347.8 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй, шүүхээр шийдвэрлүүлж чадаагүй авлагын үлдэгдэлд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй. Энэ нь харьяа яамны НБББББ-т найдваргүй авлагын зардлыг шууд болон шууд бус аргаас сонгон бүртгэхийг их сургуулиудад хүлээн зөвшөөрсөн боловч яамнаас шууд аргаар бүртгэн санхүүгийн тайланг бэлтгэн ирүүлэхийг шаарддагтай холбоотой. Түүнчлэн сургуулийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзэхэд УБНББОУС-ын дагуу авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр толилуулахад найдваргүй авлагын зардлыг шууд бус аргаар бүртгэх нь илүү тохиромжтой байна.

Эдгээр асуудлын улмаас бид дүгнэлтээ өөрчлөөгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд Монгол улсын боловсролын их сургуулийн төв сургууль болон 11 бүрэлдэхүүн сургууль нь нийт 19,192.4 сая төгрөгийн 694 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулахаас "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" хэсэгт 267.3 сая төгрөгийн зардлын 33 мэдээллийг мэдээлээгүй, "Цалингийн зардлаас бусад Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ" хэсэгт 249.0 сая төгрөгийн 28 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч уг зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 5.5 "шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2 заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна", Төрийн аудитын

тухай хуулийн 23 дугаар зүйлд "Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 4,767.1 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илрүүлснээс 4,119.0 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 648.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгснийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад биелүүлж ажилласан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,701.1 сая төгрөгийн зөрчилд өгсөн 0.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,700.9 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2 зөвлөмжийн биелэлт 89.8 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	0.2	1	0.2	-	-	100.0
Албан шаардлага	3	1,700.9	1	1,181.0	2	519.9	69.4
Зөвлөмж	2	-	2	3,864.6	-	-	100.0
Нийт дүн	6	1,701.1	4	0.2	2	3,864.6	89.8

Үүнээс 2 зөвлөмж, 1 албан шаардлага, 1 төлбөрийн актыг бүрэн биелүүлж дараах 2 албан шаардлагыг бүрэн биелүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон, дутуу мэдээлсэн, цаашид давтан гаргахгүй байх талаар өгсөн албан шаардлагыг бүрэн биелүүлж ажиллаагүй, тайлант онд 516.3 сая төгрөгийн зөрчил,
- Захирлын Б/01 дугаар тушаалд ажилчдын мэдээллийг алдаатай, буруу бэлтгэсэнд өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч тайлант онд 3.6 сая төгрөгийн зөрчил тус тус давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхааран авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

1. Капитал банкнаас авах 2,063.11 сая төгрөгийн авлагыг Капитал банк, Монгол улсын боловсролын их сургууль, "Ви эйч энд би" ХХК-ийн гурвалсан гэрээгээр "Ви эйч энд би" ХХК руу шилжүүлэн, тус компани авлагыг дуусаагүй барилгаар барагдуулахаар тохиролцсон. Дуусаагүй барилгыг Улсын комиссын дүгнэлт гаргуулан 2021 онд сургуульд хүлээлгэн өгөхөөр гэрээнд тусгасан боловч цар тахлын улмаас тайлант онд багтаан барилгыг хүлээлгэн өгөөгүй бөгөөд удирдлагын зүгээс дараагийн тайлант жилд хүлээн авахаар тодорхой шатны арга хэмжээ авч, хуваарь гаргуулан ажиллаж байна.
2. Сургууль Чингис хаан банкны өөрийн дансанд байгаа 247.0 сая төгрөгийг Хаан банкны данс руугаа шилжүүлэн авах хүсэлтийг банкинд гаргасан боловч банкны санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан мөнгийг цувуулан өгөх талаар сургуульд мэдэгдсэн бөгөөд 2022 оны 03 дугаар сарын 11-ний байдлаар 46.0 сая төгрөгийг сургуулийн Хаан банкны данс руу шилжүүлээд байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,746.8 сая төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс, 4,552.2 сая төгрөгийн 9 алдааг залруулж, 3.6 сая төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 191.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 202.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс 142.4 сая төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ажилчдад олгосон 14.2 сая төгрөгийн цалингийн зээлийг урьдчилж төлсөн зардлаар бүртгэснийг цалингийн зээлийн авлагаар бүртгэж,
2. Капитал банкнаас авах 2,063.1 сая төгрөгийн авлагыг гурвалсан гэрээгээр "Ви эйч энд би" ХХК төлөхөөр тохиролцсон боловч уг компанийн авлагаар бүртгээгүй орхигдуулсныг "Ви эйч энд би" ХХК-иас авах авлагаар бүртгэж,
3. Тайлант онд худалдан авсан 1,409.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төлбөрийн үлдэгдэл шилжүүлсэн өдөр хөрөнгөөр бүртгэснийг хөрөнгө хүлээн авсан өдөр үндсэн хөрөнгөөр бүртгэж,
4. Газар эзэмших эрхийн 153.6 сая төгрөгийн дахин үнэлгээний бууралтыг тайлант үеийн зардлаар бүртгэснийг Засгийн газрын хувь оруулсан капиталаар бүртгэж, мөн тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдлийг 98.9 сая төгрөгөөр илүү бууруулж бүртгэснийг буцаах бичилт хийж,
5. Тайлант жилийн сургалтын төлбөрийн авлага, орлогыг 21.6 сая төгрөгөөр дутуу, 2.6 сая төгрөгөөр илүү, өмнөх тайлант жилд хүлээн зөвшөөрөх байсан 527.9 сая төгрөгийн сургалтын орлогыг тайлант жилийн орлогоор тус тус бүртгэснийг авлага, орлого, хуримтлагдсан ашгийн дансанд,
6. Тайлант жилд 166.5 сая төгрөгийн ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, буцалтгүй тусламжийн орлогыг тус тус илүү хүлээн зөвшөөрч бүртгэснийг зардал, орлогыг бууруулж,
7. 2021 оны Б/01 дугаар захирлын тушаалд 2 ажилтны албан тушаалын зэрэглэлийг зөрүүтэй баталснаас цалинг 2.7 сая төгрөгөөр илүү олгосныг аудитын явцад холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, 0.3 сая төгрөгөөр НДШ-ийн зардлыг илүү тооцоолсныг холбогдох албан тушаалтанд авлага үүсгэж,
8. Боловсрол зээлийн сангийн санхүүжилтээс 56.9 сая төгрөгөөр орлогыг илүү хүлээн зөвшөөрч бүртгэснийг урьдчилж орсон орлогоор бүртгэж, мөн 4 оюутны дадлагын зардал болох 3.0 сая төгрөгийн зардал, өглөг үүсгэж бүртгээгүй орхигдуулсныг нөхөн бүртгэж,
9. Багш нарт олгосон элсэлтийн урамшууллаас 30.7 сая төгрөгийн урамшууллыг буруу дансанд бүртгэснийг холбогдох зардлын дансанд бүртгэж, урамшууллаас 0.5 сая төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг бүртгээгүй орхигдуулсан алдааг аудитын явцад өглөгөөр бүртгэж, татварын тайланг тус тус залруулав.

4.2 Албан шаардлага

Захирлын Б/01 дугаар тушаалд ажилчдын мэдээллийг алдаатай, буруу бэлтгэн тушаалыг баталснаас 5 ажилтны 3.2 сая төгрөгийн цалин, 0.4 сая төгрөгийн НДШ-ийг тус тус илүү тооцоолон цалин олгосон, тайлант онд уг зөрчлийг давтан гаргасан, аудитын явцад хариуцсан ажилтан зөрүүтэй мэдээлэлд тайлбар болон холбогдох нэмэлт мэдээллийг гарган өгөхөөс татгалзсан.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлд "Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах", 16.1-д "Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч дараах үүрэгтэй: 16.1.3.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохгүй байх; 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон

хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид захирлын Б/01 дугаар тушаалыг захирлын холбогдон гарсан тушаалын дагуу үнэн зөв бэлтгэх, цалингийн сүлжээг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Татварын авлага, өглөгийн үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бүрэлдэхүүн сургуулиудын санхүүгийн тайланд толилуулсан ХХОАТ-ын авлага, өглөгийн үлдэгдэл нь татварын тодорхойлолтоорх үлдэгдлээс 191.0 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: ... 20.2.7.аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих..", Татварын ерөнхий хуулийн 29.1.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангаарх татварын үлдэгдлийг татварын тодорхойлолтоорх үлдэгдэлтэй тааруулах, татварын цахим системээр татварын үлдэгдэл буруу татагдсан бол харьяа татварын албандаа хандан засуулах, цаашид санхүү болон татварын тайлангийн уялдаа холбоог шалгах, үлдэгдлийг хянаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Байгуул лагын нэр	Аудиты н код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Монгол улсын боловср олын их сургууль	АХГ- 2022/10 /НА- СТА- ТӨА	Бүрэлдэхүүн сургуулиудын санхүүгийн тайланд толилуулсан ХХОАТ-ын авлага, өглөгийн үлдэгдэл нь татварын тодорхойлолтоорх үлдэгдлээс 190,977.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.	СТ-ын үлдэгдлийн татварын үлдэгдэлтэй тааруулах зөвлөмж өгсөн	1	190,977.0									1	190,977.0
2	Монгол улсын боловср олын их сургууль	АХГ- 2022/10 /НА- СТА- ТӨА	Тайлант жилийн сургалтын төлбөрийн авлага, орлогыг 21,550.0 мянган төгрөгөөр дутуу, 2,612.0 мянган төгрөгөөр илүү, өмнөх тайлант жилд хүлээн зөвшөөрөх байсан 527,870.9 мянган төгрөгийн сургалтын орлогыг тайлант жилийн орлогоор тус тус хүлээн зөвшөөрч бүртгэсэн алдааг гаргасан байна.	СТ-д авлагын үлдэгдэл, СҮДТ-д орлого залруулав	1	552,032.9	1	552,032.9								
3	Монгол улсын боловср олын их сургууль	АХГ- 2022/10 /НА- СТА- ТӨА	Боловсрол зээлийн сангийн санхүүжүүлтээс 56,871.0 мянган төгрөгөөр орлогыг илүү хүлээн зөвшөөрч бүртгэсэн, 4 оюутны дадлагын зардал болох 3,036.0 мянган төгрөгөөр зардал, өглөг үүсгэж бүртгээгүй тус тус алдааг гаргасан байна.	СҮДТ-д орлого залруулав	1	59,907.0	1	59,907.0								
4	Монгол улсын боловср олын их сургууль	АХГ- 2022/10 /НА- СТА- ТӨА	Тайлант жилд 166,545.0 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, буцалтгүй тусламжийн орлогыг тус тус илүү хүлээн зөвшөөрсөн.	СҮДТ-д орлого болон зардлыг залруулав	1	166,545.0	1	166,545.0								
5	Монгол улсын боловср олын их сургууль	АХГ- 2022/10 /НА- СТА- ТӨА	2021 оны Б/01 дугаар захирлын тушаалд 2 ажилтны албан тушаалын зэрэглэлийг зөрүүтэй баталснаас 2,669.5 мянган төгрөгийн цалингийн зардал, 315.1 мянган төгрөгийн НДШ-ийн зардлыг тус тус илүү тооцоолж цалинг олгосон байна.	СҮДТ-д цалингийн зардлыг залруулж, илүү олгосон цалинг нөхөн төлүүлсэн	1	2,984.6	1	2,984.6								

Монгол улсын боловсролын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	Монгол улсын боловсролын их сургууль	АХГ-2022/10 /НА-СТА-ТӨА	Капитал банкнаас авах 2,063,106.5 мянган төгрөгийн авлагыг гурвалсан гэрээгээр "Ви эйч энд би" ХХК төлөхөөр тохиролцсон боловч уг компанийн авлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.	СТ-д авлагын үлдэгдлийг залруулав	1	2,063,106.5	1	2,063,106.5								
7	Монгол улсын боловсролын их сургууль	АХГ-2022/10 /НА-СТА-ТӨА	Газар эзэмших эрхийн 153,590.6 мянган төгрөгийн дахин үнэлгээний бууралтыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн, тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдлийг 98,947.7 мянган төгрөгөөр илүү бууруулсан тус тус алдааг гаргасан байна.	СТ-д үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг залруулав	1	252,538.3	1	252,538.3								
8	Монгол улсын боловсролын их сургууль	АХГ-2022/10 /НА-СТА-ТӨА	Тайлант онд худалдан авсан 1,409,753.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө хүлээн авсан өдөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй, төлбөрийн үлдэгдэл шилжүүлсэн өдөр хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.	СТ-д үндсэн хөрөнгийн худалдан авалтын огноог залруулав	1	1,409,753.2	1	1,409,753.2								
9	Монгол улсын боловсролын их сургууль	АХГ-2022/10 /НА-СТА-ТӨА	Багш нарт олгосон элсэлтийн урамшууллаас 30,680.0 мянган төгрөгийн урамшууллыг буруу дансанд хүлээн зөвшөөрч бүртгэж, 488.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг бүртгэлд тусгаагүй тус тус алдааг гаргасан байна.	СҮДТ-нд зардлын ангиллыг залруулав	1	31,168.0	1	31,168.0								
10	Монгол улсын боловсролын их сургууль	АХГ-2022/10 /НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд ажилчдад олгосон 14,186.2 мянган төгрөгийн цалингийн зээлийг цалингийн урьдчилгаагаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	СТ-д урьдчилж төлсөн зардлыг залруулав	1	14,186.2	1	14,186.2								
11	Монгол улсын боловсролын их сургууль	АХГ-2022/10 /НА-СТА-ТӨА	Захирлын Б/01 дугаар тушаалд ажилчдын мэдээллийг алдаатай, буруу бэлтгэн тушаалыг баталснаас 5 ажилтны 3,209.9 мянган төгрөгийн цалин, 377.6 мянган төгрөгийн НДШ-ийг тус тус илүү тооцоолон цалинг олгосон, тайлант онд уг зөрчлийг давтан гаргасан, аудитын явцад хариуцсан ажилтан зөрүүтэй мэдээлэлд тайлбар болон холбогдох нэмэлт мэдээллийг гаргах өгөхөөс татгалзсан.	Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, холбогдох ажилтанд хариуцлага тооцох	1	3,587.5				1	3,587.5	1	3,587.5			
ДҮН					11	4,746,786.2	9	4,552,221.7			1	3,587.5	1	3,587.5	1	190,977.0

Монгол улсын боловсролын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Монгол улсын боловсролын Их сургууль	АХГ-2022/10 /НА-СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ" хэсэгт 267,283.6 мянган төгрөгийн 33 мэдээллийг, "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл" хэсэгт 248,984.5 мянган төгрөгийн 28 мэдээллийг ил тод байршуулаагүй, өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч уг зөрчлийг давтан гаргасан.	Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, холбогдох ажилтнуудад хариуцлага тооцох	1	516,268.1					1	516,268.1	1	516,268.1		
ДҮН					1	516,268.1					1	516,268.1	1	516,268.1		
НИЙТ ДҮН					12	5,263,054.3	9	4,552,221.7			2	519,855.6	2	519,855.6	1	190,977.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 579/АОТ-0184

Улаанбаатар хот

АХГ - 2022/10/НА - СТА - ТБА
Сахилгын шийтгэл тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын Захирлын 2021 оны Б/01 дугаар тушаалд ажилчдын албан тушаал, албан тушаалын зэрэглэл, шатлал, улсад ажилласан жилийн мэдээллийг алдаатай, буруу бэлтгэн тушаалыг баталснаас 5 ажилтны 3,209,925.25 төгрөгийн цалин, 377,577.24 төгрөгийн НДШ-ийг тус тус илүү тооцоолон цалинг олгосон, өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч уг зөрчлийг давтан гаргасан, аудитын явцад хариуцсан ажилтан зөрүүтэй мэдээлэлд тайлбар болон холбогдох мэдээллийг гарган өгөхөөс татгалзсан.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлд "Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах", 16.1 "Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч дараах үүрэгтэй: ... 16.1.3.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохгүй байх; 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх;" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухайн хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2 заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ." заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хүний нөөцийн менежер Г.Эрдэнэчимэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 3 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Алтангоод даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ХҮЛЭГТХҮННУ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ж.ЭНХТУЯА
ЧИЧИНХОРОЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засагийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-241.Docx

0001081460



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 578/А0140184

Улаанбаатар хот

АХГ - 2022/10/НА - СТА - ТДР

Сахилгын шийтгэл тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" хэсэгт орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй, 267,283,553.65 төгрөгийн зардлын 33 гүйлгээг мэдээлээгүй, "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл" хэсэгт 248,984,506.00 төгрөгийн 28 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч уг зөрчлийг дахин давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"; 5.5 "шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2 заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна", Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлд "Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухайн хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2 заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ." заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

- Дээрх зөрчлийг гаргасан бүрэлдэхүүн сургууль бүрийн шилэн данс хариуцсан ажилтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Алтангоод даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТЫГ ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН,
ХҮЛЭГТ ХҮННҮ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ж.ЭНХТУЯА
Ч.ИЧИНХОРОЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

4006100
170.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-240.Docx
9019120366

0001081462

[illegible]

[illegible]